

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 30 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны аравдугаар сарын 30-ны 14 цаг 26 минутад эхэлж, 15 цаг 07 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 41 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд нээлттэй зарлах тухай	Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж.Санжжавын 2014 оны 10 дугаар сарын 24, 2014 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 282 тоот албан бичгээр Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга ирүүлснийг хэлэлцээд, 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлан, 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар тогтлоо.
2	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд нээлттэй зарлах тухай	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгийн 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн ХЭГ/1732 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга ирүүлснийг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлан, сонгон шалгаруулалтыг

		зохион байгуулахаар тогтлоо.
3	Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.5 дахь заалтыг "Энэхүү журмын 2.4.1-д заасны дагуу төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах, сонгон шалгаруулалт явуулах комиссыг Салбар зөвлөлийн даргын шийдвэрээр тухай бүр байгуулна" гэж, 2.6 дахь заалтыг Комисс дүгнэлт болон сонгон шалгаруулалтын дүнг Салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулна" гэж тус тус өөрчлөх.</p> <p>2. Журмын 2.7 дахь заалтыг "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах, сонгон шалгаруулалт явуулах комиссыг тухайн яам, агентлагийн дэргэдэх Салбар зөвлөл арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавина" гэж нэмэх.</p> <p>3. Журамд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөх.</p> <p>1. 4.Энэхүү өөрчлөлтийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдэд зөвлөмжийн хамт хүргүүлэхийг Ажлын алба /С.Цэдэндамба/-нд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

